



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

2016 он 12 сарын 28 өдөр

Дугаар ЗГ-1/264

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
М.ЭНХБОЛД ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2016 он 12 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар ХЭГ/2289

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Ц.ЦОЛМОН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацаа товлох тухай

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Ж.МӨНХБАТ

X-9

003696

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 63 дугаар тэмдэглэлд:

“ХҮИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mjia.gov.mn,  
http://www.mjia.gov.mn


2016.12.28 № 1-1 / 2289

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**САНГИЙН САЙД Б.ЧОЙЖИЛСҮРЭН  
ТАНАА**

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтыг үндэслэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.

САЙД



С.БЯМБАЦОГТ

Doc.said a5.2016

08 2385



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,  
Утас/факс: 26-74-68, <http://www.mof.gov.mn>

*2016.12.28* № *3-2/7726*


танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Ж.МӨНХБАТ ТАНАА**

Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон тул хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрч байна.

Жич: Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн зөвшөөрлийг хавсаргав.

Хүндэтгэсэн,



**Б.ЧОЙЖИЛСҮРЭН**

002558



**ТАТВАРЫН МЭРГЭШСЭН  
ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГ**

211213 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 3-р хороо  
Токиогийн гудамж "Оршил төв" 5 дугаар давхар

Утас: 76118989 Email: info@сpta.mn

2016. 12. 28. №. 02/116 Танай  
-ны №. -г

**САНГИЙН ЯАМАНД**

Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуульд  
нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дэмжиж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

  
Ц.БОЛОРМАА

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлд дараахь агуулгатай 40.4 дэх хэсэг нэмсүгэй:

“40.4. Энэ хуулийн 40.2-т заасан хугацааг төсөл, арга хэмжээний цар хүрээ, хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааруулан дахин 2 жил хүртэл хугацаагаар сунгах шийдвэрийг Засгийн газар гаргаж болно.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2017 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



**ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Улсын Их Хурлын 2012 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Үйлдвэржүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын хүрээнд” барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, цемент, төмөр хийц, шил, дулаалгын материал зэрэг бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтлах, түүнчлэн импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихээр тусгасан болно.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор 2014 оны 6 дугаар сарын 06-ны өдөр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулж, улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор оруулж ирж байгаа техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдлийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 2 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Улсын Их Хурлаас дээрх шийдвэрийг гаргасантай холбогдуулан Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2015 оны 189 дүгээр тогтоолоор хөрөнгө оруулагч болон тухайн хөрөнгө оруулалт хийгдэх салбарын эрхэлсэн сайдтай гурвалсан гэрээг хамтран байгуулж, албан татвар хойшлуулах хугацаа болон төлөх татварын хэмжээг нарийвчлан тогтоохыг Сангийн сайдад үүрэг болгосон болно.

Одоогийн байдлаар “Байшин үйлдвэрлэх комбинат-1” төслийг хэрэгжүүлэгч “Эрэл” ХХК-тай 2015 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 15/19/15 тоот гурвалсан гэрээ, “Монцемент” төслийг хэрэгжүүлэгч “Сэнж сант” ХХК-тай 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 79/33/25 тоот гурвалсан гэрээг тус тус байгуулсан бөгөөд “Хөх цавын цемент-шохойн үйлдвэр”-ийн төслийг хэрэгжүүлж байгаа “Монголын Алт” (МАК) ХХК-тай гэрээ байгуулахаар ажиллаж байна.

Улсын хэмжээний томоохон төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьд хэрэгжүүлж байгаа төслийн цар хүрээ, хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч бүтээн байгуулалтын ажил хуульд заасан 2 жилийн



хугацаанд хийгдэж амжихааргүй байгаа тул үүсээд буй нөхцөл байдалтай уялдуулан татвар төлөх хугацааг дахин 2 жил хүртэл хугацаагаар сунгах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй байна.

**Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь 2 зүйлтэй байх ба үүгээр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлд төсөл, арга хэмжээний цар хүрээ, хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааруулж татвар төлөх хугацааг дахин 2 жил хүртэл хугацаагаар сунгах шийдвэрийг Засгийн газар гаргах тухай зохицуулалт болон хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацааг заана.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуульд дээрх нэмэлтийг оруулснаар улсын хэмжээний томоохон төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийн бүтээн байгуулалтын хугацаанд гарах зардлын 15.5 хувийг хэмнэх боломжийг олгох юм.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаархи санал**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцсэн байна. Энэ хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орохгүй болно.

---o0o---

## ТАНИЛЦУУЛГА

*Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн тухай*

Улсын Их Хурлын 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Үйлдвэржүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын хүрээнд” барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, цемент, төмөр хийц, шил, дулаалгын материал зэрэг бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтлах, түүнчлэн импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихээр тусгасан болно.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор 2014 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулж, улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор оруулж ирж байгаа техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдлийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 2 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Улсын Их Хурлаас дээрх шийдвэрийг гаргасантай холбогдуулан “Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 189 дүгээр тогтоолоор хөрөнгө оруулагч болон тухайн хөрөнгө оруулалт хийгдэх салбарын эрхэлсэн сайдтай гурвалсан гэрээг хамтран байгуулж, албан татвар хойшлуулах хугацаа болон төлөх татварын хэмжээг нарийвчлан тогтоохыг Сангийн сайдад үүрэг болгосон.

Одоогийн байдлаар “Байшин үйлдвэрлэх комбинат-1” төслийг хэрэгжүүлэгч “Эрэл” ХХК-тай 2015 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 15/19/15 тоот гурвалсан гэрээ, “Монцемент” төслийг хэрэгжүүлэгч “Сэнж сант” ХХК-тай 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 79/33/25 тоот гурвалсан гэрээг тус тус байгуулсан бөгөөд “Хөх цавын цемент-шохойн үйлдвэр”-ийн төслийг хэрэгжүүлж байгаа “Монголын Алт” (МАК) ХХК-тай гэрээ байгуулахаар ажиллаж байна. Төлөх татварын хэмжээг харуулбал:

<b>Аж ахуйн нэгж</b>	<b>2016 он</b>	<b>2017 он</b>
“Сэнж сант” ХХК	1.4 тэрбум төгрөг	17.5 тэрбум төгрөг
“Эрэл” ХХК	-	4.9 тэрбум төгрөг
“Монголын Алт” ХХК	-	-

Улсын хэмжээний томоохон төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьд хэрэгжүүлж байгаа төслийн цар хүрээ, хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч бүтээн байгуулалтын ажил хуульд заасан 2 жилийн хугацаанд хийгдэж амжихааргүй байгаа тул үүсээд байгаа нөхцөл байдалтай уялдуулан татвар төлөх хугацааг дахин 2 жил хүртэл хугацаагаар сунгах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй байна.

Хуульд дээрх нэмэлтийг оруулснаар улсын хэмжээний томоохон төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийн бүтээн байгуулалтын хугацаанд гарах зардлын 15.5 хувийг хэмнэх боломжийг олгох юм.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн  
төслийг хэлэлцүүлэх ажлын хэсгийн нэрс

Д/д	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар
1.	Ж.Ганбат	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	99993752
2.	Э.Алтанзул	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга	99092049 62264193
3.	С.Тулга	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн	98110000

-----ooOoo-----